

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэл №2

Үндэсний зөвлөлийн хуралдаан Монгол улсын Ерөнхий сайдын уулзалтын танхимд 2008 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн 17 цаг 10 минутад эхлэж 18 цаг 15 минутад дуусав.

Хуралдаанд Монгол улсын Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга С. Баяр болон Үндэсний зөвлөлийн гишүүд: Сангийн сайд Ч. Улаан, Үйлдвэр худалдааны сайд Х. Наранхүү, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаяр, Үндэсний статистикийн газрын дарга П. Бямбацэрэн, Шадар сайдын ахлах зөвлөх Д.Даваасүрэн, Байгаль Орчны сайд Г.Шийлэгдамбыг төлөөлж Дэд сайд Д.Дэлгэрцогт, Эрдэнэт үйлдвэрийн ерөнхий захирал Ч. Ганзоригийг төлөөлж тус үйлдвэрийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын дарга Д.Цогбаатар, Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгааг төлөөлж тус ассоциацийн олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн Д. Хосбаяр, Уул уурхайн ассоциацийн хүндэт ерөнхийлөгч П.Очирбатыг төлөөлж тус ассоциацийн ерөнхийлөгч Д.Ганболд нар оролцов. Хуралдааны ирц 59 хувь байв.

Түүнчлэн хуралдаанд Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Байгаль Орчны яамны газрын дарга Ц. Банзрагч, Сангийн яамны газрын дарга Ж.Үхэртар, ахлах мэргэжилтэн Х.Ундраа, ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Ажлын албаны санхүүгийн ажилтан Т.Хүрэлчимэг нар оролцов.

Хуралдаанаар хэлэлцсэн асуудал:

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын аудитын дүнг нэгтгэсэн Монгол Улсын анхдугаар тайланд гарсан нийт 25 тэрбум төгрөгийн дүн бүхий албан татвар, төлбөрийн зөрүүний үндэслэлийг тохиолдол бүрээр судалж, шалтгааныг тогтоон, дутагдлыг арилгах зохион байгуулалтын арга хэмжээ авсан тухай танилцуулга. Сангийн сайд Ч.Улаан

Хуралдааныг Сангийн сайд Ч. Улаан нээж, хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Ч. Улаан: Ерөнхий сайд уулзалт нь хараахан дуусаагүй байгаа тул ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн хуралдаанаа эхэлж байна уу гэсэн саналыг тавьсан юм. Хуралдаанаа эхлэхийг та бүхэн зөвшөөрч байна уу?

Бүгд: Тэгье.

Ч. Улаан: Өнөөдөр бид ОУИТБС-ийн 2006 оны тайлангийн зөрүүг Сангийн яамнаас тодруулсан тухай асуудлыг хэлэлцэх юм. Энэ тодруулгыг би Та бүхэнд танилцуулая. /Тодруулгыг хавсаргав./

Ч.Улаан. Тайлантай холбогдуулж асууж тодруулах зүйл байна уу?

Д.Дэлгэрцогт: Энэ зөрүү гарахад санаатайгаар, хариуцлагагүй үйл ажиллагаанаас болсон байдал байна уу?

Ж. Үхэртар: Энэ зөрүүг тодруулах явцад санаатайгаар гаргасан алдаа байна гэхээр зүйл ажиглагдаагүй ээ. Харин зарим юман дээр хариуцлагагүй байдлаас болж зөрүү гарсан нь аль аль талдаа байгаа. Зарим компани зарим татварыг нэгтгээд бичсэн байна билээ.

Х. Наранхүү: Татвар төлөгч компаниуд Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу санхүүгийн үйл ажиллагаагаа үнэ зөв тайлагнах талаар хангалтгүй байгаа бөгөөд түүнийг хүлээн авч буй төрийн байгууллагуудын хариуцлага, хоорондын ажлын уялдаа холбоо шаардлагын хэмжээнд хүрээгүй байгааг харуулж байна гэсэн дүгнэлтэн дээр тэр хариуцлагын талаар тодорхой бичигдээгүй байна.

Ч. Улаан: Тайлан гаргагч компани олон улсын стандарт, журам, дүрмийн дагуу гаргаагүй тал бий. Тайлангаас харахад нягтлан бодох бүртгэлийн програмаа цэгцлэх шаардлагатай нь харагдлаа. Яг санаатай биш мөртлөө хэнэггүй хандсан зүйлүүд байгаа. Нэмэгдсэн өртгийн албан татварыг гаалийн татвар гэж мэдээлсэн гэх мэтийн зөрчлүүд гарсан. Тэгэхээр холбогдох албан тушаалтнуудад зааж зөвлөх, тэднийг сургах шаардлага бас байгаа.

Х. Наранхүү: Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэл хөтлөнө гэдэг шаардлагыг бүх компанид тавих хэрэгтэй. Олон улсын ийм программ нь дүн шинжилгээ хийх боломжтой. Үнийн хувьд 10 гаруй мянган ам.доллар байдаг. Гэхдээ энэ тайлан чинь бол жинхэнэ санхүүгийн тайлан биш харин тодорхой асуудлыг хөндсөн хэсэгчилсэн маягийн тайлан шүү дээ.

Ерөнхий сайд С.Баяр хуралдаанд орж ирэв.

Д.Ганболд: ОУИТБС-ын 2006 оны тайланд 25 компанийн тайланг оруулсан. Энэ бол түүвэр маягийн аудит болсон л доо. Монголд олборлох үйлдвэрлэл эрхэлдэг 1000 орчим байгууллага байдаг гэсэн тооцоо байдаг боловч яг компани тус бүрээр бүртгэсэн бүртгэл байдаггүй. Манай Уул уурхайн үндэсний ассоциаци энэ талаар бүртгэл хийж, мэдээлэл цуглуулж байгаа, ер нь цэгцлэх санаа байна. Энэ 25-аас гадна 900 гаруй аж ахуйн нэгж үнэхээр үйл ажиллагаа явуулдаг уу, 2 данстай байна уу, татвараа төлдөг үү, хэдий хэр юм төлж байна гэдэг бол үнэхээр хэцүү асуудал болчихоод байна. Ялангуяа зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар 68 хувь байгаа цагт компаниуд 2 данстай байх гэдэг ойлголт, татвараас нуугдах гэсэн зүйлүүд байсаар л байх болно. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар төлж байгаа компаниуд хэзээ ч нөхөн сэргээлт хийхгүй ээ, нөхөн сэргээлт хийвэл хаанаас мөнгө олов гэдэг асуулт гарна. Энэ 25 компаниас гадна байгаа 900 гаруй компаниудыг яах юм бэ. Тэр ня-бо бүртгэлийн програм хангамж энэ тэрд нь шаардлага тавих хэрэгтэй, татварыг далд болгоод байгаа хуулийн орчноо эргэж харах хэрэгтэй байна. Энэ нь эргээд ил тод байдлаа алдагдуулж байна. Ер олборлох салбарт нэгдсэн бодлого хэрэгтэй байна гэж үзэж байна.

Д.Цогбаатар: Тайланг боловсронгуй болгож, хүмүүсийг сургана гэжээ. Компаниуд олон газар тайлан гаргадаг, олон шат дамжлага дамждаг зэргээс болоод алдаа их гарч байгаа боловч уу гэж бодлоо. Ер нь компаниуд шууд Сангийн яаманд тайлангаа гаргаад өгчихдөг байвал яасан юм бэ?

Ч.Улаан: Д.Цогбаатар гишүүний саналыг дэмжиж байна. Цаашдаа ингэх боломжтой эсэхийг судлая. Нэг газраа баталгааждаг байна гэдэг бол зөв санал байна. Д.Ганболд даргын тэр бүртгэл сайжруулах, бодлого боловсруулах асуудлыг ч авч үзэх хэрэгтэй юм байна.

Э.Сумъяа: Энэ тайлан гаргалтын талаар 1 тодруулга хэлье. Энэ тайлан бол төрийн байгууллагуудад зориулж биш олон нийтэд зориулагдсан тайлан. Компани болон татвар, хураамж авсан байгууллагууд гэсэн 2 талаас тус тусдаа тайлан гаргаад түүнээ олон нийтэд мэдээлж байгаа. Харин энэ хоёр тайлангийн зөрүүгий нь олох зорилготой хийгдэж байгаа аудит юм аа. Хэрэв компаниуд Сангийн яаманд тайлангаа өгөөд тэр тайлантай нь адилхан тайлан Сангийн яам гаргаад байвал энэ ил тод байдлын зарчим, аудитын маань утга учир алдагдана.

С. Баяр: Хоёр хурал давхцчихаад хоцорч орж ирлээ. Сангийн яамнаас аудитын зөрүүний учир шалтгааны тухай хийсэн мэдээллийг та бүхэн хэлэлцлээ. Олборлох үйлвэрлэл гэдэг бүх л хүний анхаарал татсан, бүгд ярьдаг, сонирхдог сэдэв болчихлоо. Үнэхээр ч өнөөгийн байдалд тэгэхээс аргагүй. ОУИТБС бол зөвхөн манайд хэрэгжээд байгаа юм биш, энэ нь олон улсын хувьд анхаарал татсан асуудал болжээ. ОУИТБС-ын талаар Нэгдсэн Үндэстний байгууллага тогтоол гаргах чиглэлээр ажиллаж байна. Олон улсын байгууллагаас тусгай зөвшөөрлийн олголт, төсвийн зарцуулалтыг ил тод болгох чиглэлээр ажиллах тухай ярьж эхэлж байна. Энэ тайлан нь төрийн захиргааны байгууллагуудад зориулсан биш, олон нийтэд зориулсан тайлан.

Та бүхэн мэдэж байгаа. Олон улсын аудитаар 25 тэрбум төгрөгийн зөрүү гарсан. Зөрүү гарсан учир шалтгааныг магадлах үүргийг Үндэсний зөвлөлийн өмнөх хуралдаанаас Сангийн яаманд өгсөн. Сангийн яам ч үүн дээр нухацтай ажиллаж зөрүүний тохиолдол бүрийн учир шалтгааныг олж мэдээлэл хийлээ. Хэд хэдэн ноцтой анхаармаар зүйл гарсан. Тайлангийн маягтуудыг шинэчлэн баталсан. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 300 гаруй компаниас 130 гаруй компанийн тайланг гаргасан.

Цаашид хийх ажил их байна. Гүнзгийрүүлэн судлах асуудал ч байна.

Шийдвэрлэсэн нь: 1. 2006 оны тайланд хийсэн аудитын дүгнэлт болон Сангийн яамны гаргасан тодруулга дээр Үндэсний аудитын газраар цаашид гүнзгийрүүлэн шалгуулах асуудлыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д. Батбаярт даалгав.

2. Бид ОУИТБС-ын 2006 оны тайланг хангалттай эсэхийг шийдэж, хангалттай гэж үзсэн тохиолдолд батлах ёстой байгаа. Би хангалттай гэж үзээд батлах саналтай байна. Санал хураая. Бүгд : Гар өргөн батлав.

ОУИТБС-ын 2006 оны олон улсын аудитын тайланг, Сангийн яамнаас хийсэн тодруулгын хамт хангалттай гэж үзэж батлав.

3. Үндэсний зөвлөлөөр баталсан олон улсын аудитын тайланг, Сангийн яамны тодруулгын хамт олон улсын холбогдох байгууллагуудад явуулах асуудлыг ажлын албаны зохицуулагч Ш. Цолмонд даалгав.

С.Баяр -Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг цаашид улам боловсронгуй болгох чиглэлээр анхаарах асуудал олон байна. Түрүүчийн хуралдаанаас хойш 25 тэрбумын зөрүүний талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар янз бүрийн мэдээллүүд гарсан. Олон нийт асуудлын учир шалтгааныг их сонирхож байна. Төрийн байгууллага юу хийв, аж ахуйн нэгж юу хийв, төрийн бус байгууллага нь юу хийв гэж харж байна. Тиймээс Сангийн яамнаас зөрүүг нягталсан талаар, өнөөдрийн хуралдааны талаар, гаргасан шийдвэрүүдийн талаар, энэ санаачлагын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх шаардлагатай байна. Энэ чиглэлээр Д.Батбаяр хэвлэлд ярилцлага өгөх хэрэгтэй. Мөн Сангийн яам, Үндэсний зөвлөл, ажлын албанаас мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэх нь зүйтэй. Бид тайлангаа олон улсын байгууллагад явуулахаар сая тогтлоо. Ингэж ажиллаж байж бид дотоод, гадаадад ил тод байдлаа хангана.

Олборлох үйлдвэрлэлийн салбарыг мэддэггүй хүнгүй болсон онцлог салбар аа. Иймд бид мэдээллийг сайн өгч ажиллах нь чухал юм.

Ер нь энэ байдлаас харахад бидний тайлан мэдээллийн систем дэлхийн практикаас хоцорсон байгаа нь харагдаж байна. Нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо олон улсын стандартад хийцээгүй байгаагийн буруугийн тодорхой хэсэг Засгийн газарт оногдох ёстой. Санхүүгийн тайланг ер хүн ойлгоход хэцүү байгаа, иймд хэнд ч ойлгомжтой болгох шаардлага гарч байна. Компьютерийн нэгдсэн системд холбогдсон байхад тайлан гаргахыг хялбаршуулж болох юм.


Бид хүмүүсээ сургахад дутуу анхаарсан байна. Төрийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хийх зүйл их байна.

Бүх сонирхогч талыг найдвартай мэдээллээр хангах нь Үндэсний зөвлөлийн гол ажил аа. Мэдээллийн системд төрийн захиргааны байгууллагууд, томоохон компаниуд холбогдвол тайлангийн эцсийн дүнгээр төдийгүй, явцад нь хянах боломж ч гарна. Үүнийг ашиглах хэрэгтэй.

Үндэсний зөвлөлийн дараагийн хуралдаанаар юу хэлэлцэх талаар бэлтгэх, бидэнд байгаа боломжоо бид ашиглах нь чухал байна.


За ингээд өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон та бүхэнд талархаж байна.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан:
Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга



Д.Батбаяр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:
ОУИТБС-ын Ажлын албаны ажилтан



Т.Хүрэлчимэг